

**ХӨГЖМИЙН ЗОХИОЛЧИЙН
ТУУЛСАН ЗАМ
Г. Гунгаа**

Хөгжмийн зохиолч Ши Шинхай 1905 онд Гуан дүн мужийн Фань юй сяньд ядуу тариачны гэр бүлд төржээ. Ши Шинхайгийн гэр бүл амьдралын шаардлагаас болж Сингапурт очиж амьдарч байсан ба Ши Шинхай бага сургууль төгссөнийхөө дараа дунд сургуульд суралцах насандаа эх орондоо буцаж ирэв. Амьдрахын тулд суралцахын зэрэгцээгээр ажил хийх шаардлагатай байсан тул Ши Жинхай ажил сургууль хоёрыг хослуулдаг байв.

Ши Шинхай 1924 онд Гуанжоу хотын Линьнаны их сургуулийг төгсөөд тэр сургуульдаа үлдэж хөгжмийн багшаар ажиллаж байгаад 1926 онд Бээжин их сургуулийн хөгжмийн ангид орж суралцаад дараа жил нь Шанхайд очиж, хөгжмийн дээд сургуульд орж суралцсан боловч хувьсгалын ажилд оролцож байсан учраас удалгүй тус сургуулиас хөөгджээ.

Тэрбээр 1929 онд хөгжмийн урлагийн талаар мэргэжил дээшлүүлэхээр Парис хотноо очив. Тэнд суралцахын хажуугаар хоолны газар үйлчлэгч, цайны газар цэвэрлэгч, хөгжмийн багш зэрэг ажлыг хийдэг байв. Парис хотноо бараг долоон жил болоод 1935 оны зун эх орондоо буцаж ирэв.

Ши Шинхай 1938 онд Янь аньд очиж Лү шүний нэрэмжит урлагийн дээд сургуулийн хөгжмийн салбарын эрхлэгчээр ажиллав. Тэнд байсан хоёр жил хагасын дотор Монголд шар мөрний долоон дуу хэмээн алдаршсан «Шар мөрний магтуу», сүүлд нь Хятадын төрийн дуулал болгож найруулсан «Хятадын ардын арми ба ард түмний марш», «Есдүгээр сарын арван найман», «Хятадын залуучуудын марш» зэрэг том хэмжээний ая бичиж туурвижээ.

Ши Шинхай 1939 онд Хятадын коммунист намд оржээ. 1940 онд Янь ань-аас Зөвлөлүүдийн орны хувьсгалт урлагаас суралцахаар Москва хотноо очихоор гарчээ. Гэтэл энэ үед дайны хүнд үе тохиолдсон учраас Монголд үлдэж 1940—1943 онуудад амьдарч байв. Монголд байхдаа Кун юй гэдэг нэртэй байсан ба тэр үед Улаанбаатар хотод байсан Хятад ажилчны клуб (Хятад ши юанз)-ын хөгжмийн багшаар ажиллаж байв.

Ши Шинхай бол төгөлдөр хуур, модон үлээвэр хөгжим, хийл зэрэг олон хөгжмийг чадмаг эзэмшсэн хүн байв. Тэр үед хөгжмийн залуу зохиолч Мөрдорж, Цэрэнпил нар хөгжмийн онол заалгахын тулд Ши Шинхайд шавь орж хичээл заалгадаг байсан ба хятад клубын хөгжимчид, сайн дурын уран сайханчид болон хөгжим сонирхогчид хийл хөгжим заалгадаг байв. Ши Шинхай Азийн орнуудын хөгжмийн урлагийн санд өвөрмөц маягаар хэрэглэж ирсэн тоон бичиг (тоо нот)-ийг анх удаа манай хөгжимчдөд зааж сургасан хүн юм.

Тэр үед радио нэвтрүүлэг явуулахдаа нэвтрүүлэгт оролцох хүмүүс радио хороон дээр биеэрээ очиж шууд нэвтрүүлэг хийдэг бай-

сан. Ши Жинхай өөрийнхөө хуваарьтай өдрүүдэд радио хороон дээр очиж хөгжмийн аянуудыг хөгжимдөх ажилд идэвхтэй оролцдог байв. Мөн Ши Шинхай-гийн зохиосон, хөгжимдсэн хөгжимт нэвтрүүлгийг радиогоор байнга нэвтрүүлдэг байв.

Ши Шинхай Монголд байхдаа хөгжмийн зохиолч Мөрдоржийн зохиосон «Байлдаан ч суман», «Залуу жанжин Лхагвасүрэн» гэдэг дууны аяыг найрал дуу болгон ардын цэргийн дуу бүжгийн чуулгын дуучдад заах үед аяыг нь бичиж найруулах ажилд туслаж биечлэн оролцож, «Улаанбаатарын өглөө» гэдэг хөгжим зохиож, олон хөгжимчдэд хийл хөгжим зааж сургажээ. «Байлдаан ч суман», «Залуу жанжин Лхагвасүрэн» гэдэг дуунуудыг ардын цэргийн дуу бүжгийн чуулгын үлгэр жишээ үлээвэр хөгжим одоо хир нь Ши Шинхай-гийн найруулсан аяар сэргээн хөгжимдөж байгаа нь дурсгал болон үлджээ. Үүнээс гадна Ши Шинхай улсын төв театр, Ленин клуб, Цэргийн дуу бүжгийн чуулга болон хорооны клубүүдэд очиж хөгжим зааж, концерт тоглоход нь байнга оролцдог байв. Үүний зэрэгцээгээр Ши Шинхай Мижид жанжны удирдлагын дор байгуулагдсан «сайн дурын морьт отряд»-ын гишүүнээр элсэж, эргүүл манаанд гарах, байлдааны бэлтгэл сургууль хийх ажилд тогтмол оролцдог байсан ба тэр үед «сайн дурын морьт отряд»-ын гишүүд өмсдөг байсан таван хошуутай, шовгор оройтой малгайг байнга өмсөж явдаг хүн байв. Энэ байдлаас үзэхэд Ши Шинхай бол Монголд хувьсгалт урлагийг хөгжүүлэх үйл хэрэгт зохих хувь нэмрээ оруулсан хүний нэг юм.

Ши Жинхай Монголд байхдаа нэгэн жижиг өрөөнд суудаг, гэрт нь төгөлдөр хуур, модон үлээвэр хөгжим, хийл хөгжим, ширээ сандал болон айл саахалтын хүмүүсээс бүр, түр өгсөн аяга, таваг, савх зэргээс өөр зүйлгүй, ер нь илүү дутуу хөрөнгө хогшилгүй их л энгийн амьдардаг байв.

Ши Шинхайгийн музейг Бээжин хотын дүүрэгт байгуулсан. Тус музейн үзмэр дотор Монголд байхдаа хэрэглэж байсан төгөлдөр хуур нь байх боловч, гэрт нь байнга байдаг, хором тутамд хэрэглэж байсан модон үлээвэр хөгжим, хийл хоёр нь байхгүй байх ба бодоход устаж үгүй болсон нь харамсалтай. Ши Шинхай нутгаасаа гарахдаа зааны ясан тоногтой модон үлээвэр хөгжим хоёр ширхэгийг авч гарсан ба тэр нь түүний насан туршдаа хэрэглэж явсан үнэт эдлэл нь байсан боловч Монголд хил зөрчиж ирсэн хэрэгт мөрдөгдөж байх үед нь эл хоёр хөгжмийг хурааж авсан байх тул энэ хоёр хөгжим одоо аль нэг газрын санд хадгалагдаж байж ч болох юм.

Ши Шинхай ЗХУ-д очоод Москва хотод байхдаа «Хятадын 8-р арми» гэдэг кино бүтээхэд оролцож, «Шар мөрний магтуу» гэдэг хөгжмийнхөө хоёр дахь бичлэгийг туурвиж, бас олон тооны хөгжмийн аялгуу зохиосон боловч зарим зүйл нь одоо хир нь олдохгүй болсон юм. Хятадын хэвлэлийн мэдээнээс үзвэл 100 гаруй том жижиг ая зохиосон гэдэг мэдээ байгаа боловч бас л бүрэн биш юм.

Зөвлөлтийн нэрт хөгжмийн зохиолч Глиэрийн шавь Ши Шинхай Кремлийн эмнэлэгт хэвтэж эмчлүүлж байгаад 1945 оны 10 сарын 31-нд уушигны өвчнөөр нас баржээ. Хөгжмийн зохиолч Ши Шинхайгийн чандрыг Москвагаас авчруулах тухай хүсэлтээ Хятадын засгийн газар ЗХУ-ын ГЯЯ-нд уламжилж уг хүсэлтийг ёсоор болгосон байна. Ши Шинхайг Соёлын хувьсгалын үед Жянчин болон «дөрвийн» бүл

гийнхэн суртал нэвтрүүлэгтээ ашиглах гэж оролдсон боловч тэд нэрт зүтгэлтний гандан бууршгүй бүтээлийн нь үнэ цэнийг бууруулж чадаагүй юм. Харин ч Ши Шинхайгийн уран бүтээл нь Хятадын орчин үеийн хөгжмийн урын санд зүй ёсныхоо байр суурийг эзэлж, ард түмний сэтгэлд мөнх дурсагдах үнэ цэнтэй бүтээл болохоо харуулав.

Хятадын орчин үеийн хөгжмийн урлагийг үндэслэгч, хөгжмийн зохиолч, хөгжмийн удирдаач Ши Шинхай бол Монгол-Зөвлөлт-Хятадын ард түмний найрамдлыг хөгжүүлэх үйл хэрэгт оролцож, найрамдлын эх суурийг тавилцсан хүний нэг бөгөөд хөгжмийн урлагийн өндөр боловсролтой, бүтээлч сэхээтэн байсны нь хувьд Ши Шинхайгийн уран бүтээлийг цаашид нарийвчлан судлах нь зүйтэй юм.

Хятадын коммунист нам, Хятадын хувьсгалыг манай ард түмэн анх үүсэхээс нь эхлэн талархан дэмжсэн түүхтэй. Энэ талаар дурьдвал олон баримт бий бөгөөд олон хүний овог, нэр, олон хүний түүх намтар, олон үйл явдлыг дурьдаж болох юм. Хятадын хувьсгалчид, тэдний гэр бүлийн хүмүүс Монголд ирж байрлаж байх үед манай зүгээс хөрш орны хувьд бололцооныхоо хирээр туслаж байв. Түүнчлэн Хятадын хувьсгалчдаас зөвлөлүүдийн оронд очиж суралцах, хувьсгалын туршлага судлах, төрөл бүрийн тусламж авахаар дайран өнгөрөх, коминтерны удирдагчидтай уулзах, тэнд суух бие төлөөлөгчийг дамжин өнгөрөх үед шаардагдах арга хэмжээг авч туслаж байв.

Энэ өгүүлэлд зөвхөн нэг хөгжимчний тухай дурьдаж байгаа боловч Монгол-Хятадын ард түмний харилцааны түүхэнд бий болсон хувьсгалт, шинэ маягийн харилцааны сайхан эхлэлийн нэгэн баримт даруй мөн юм.